



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№180 /390/

2022.10.07

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 3	☁️ -7

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 32	☁️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.410.00	3.460.0
EUR 🇪🇺	3.410.0	3.460.0
CNY 🇨🇳	481.00	485.00
RUB 🇷🇺	52.70	53.30
JPY 🇯🇵	24	24.40
KRW 🇰🇷	2.37	2.42

ЗУРХАЙ



2022.10.07 /БААСАН ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 12

**НАМРЫН ДУНД САРЫН
ШАРАГЧИН ТАХИА САР
ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ
ХАРАГЧИН МОГОЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Өвчин эмгэг ирнэ

Наран ургах, шингэх:

06.59-18.21

Барилдлага:

Шид

Шүтэн барилдлага:

Хурьцахуй

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Шүтээн босгох, хот балгадыг барих, тариа тарих, худалдаа наймаа хийх, шид бүтээл үйлдэх тарни тоолох болон дэлгэрүүлэх үйл бүхнээ сайн болой, бурханы үйл, хувцас хийхэд сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун чих цангинавал үзэсгэлэн болох, зүүн нь бол үхэл болсныг сонсох, нохой уливал сонсголонтой үг сонсох, тагнай загатнавал гэр арвидах, бие татвал 1-2 хүн ирэх, хөл татвал гомдол аюул болно.



**КОРОНАВИРУС
ДЭЛХИЙ ДАХИНД**

Тохиолдол

Нийт: 624,971,219

Эдгэрсэн

Нийт: 604,825,983

Нас барсан

Нийт: 6,555,522

ҮБХИС-ИЙН ЭРДМИЙН ХАМТ ОЛОНДОО ДЭЛХИЙН БАГШ НАРЫН 28, МОНГОЛЫН БАГШ НАРЫН 56 ДАХЬ БАЯРЫН МЭНДИЙГ ӨРГӨН ДЭВШҮҮЛЬЕ

Монгол Улсын мэргэжлийн боловсролын ууган сургууль болох Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн багш нарын баярын хурал ёслол төгөлдөр болж өндөрлөв.

ҮБХИС нь 1921 онд үүсэн байгуулагдсан цагаасаа улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үе үеийн шилдэг офицер, даргалах бүрэлдэхүүнийг сурган бэлтгэх үндсэн үүрэг, зорилго нэр төртэй гүйцэтгэж ирсэн бөгөөд өнөөгийн шинэ зууны дээд боловсрол, сургалтын тогтолцоон дахь нэр хүнд, байр суурь нь улам бүр өсөн нэмэгдсээр байгаа юм.

Баярын хуралд БХЯ-ны ТЗУГ-ын дарга хурандаа С.Ванчинхүү, ГХАГ-ын дарга хурандаа Б.Бат-Эрдэнэ, ЗХЖШ-ын БСТГ-ын дарга бригадын генерал Ц.Гандорж, ҮБХИС-ийн захирал бригадын генерал П.Жаргалан, "Оюутан цэрэг" хөтөлбөрийн ерөнхий зохицуулагч, Монгол Улсын Ардын багш, доктор (Sc.D), профессор Г.Мягмаржав болон тус сургуулийн эрдэмтэн багш, албан хаагчид оролцлоо.

БХЯ-ны ТЗУГ-ын дарга хурандаа С.Ванчинхүү хэлсэн үгэндээ "Монгол Улсад орчин цагийн боловсрол, соён гэгээрүүлэх их үйлсийг эхлүүлсэн нэгэн зууны түүхэн замнал тус их сургуулийн удирдлага, эрдэмтэн докторууд, хүндэт профессорууд, эрдэм шинжилгээний ажилтнууд, багш

судлаачид Та бүхэндээ Багш нарын өдрийн баярын мэндчилгээг БХЯ-ны удирдлагын нэрийн өмнөөс болон хувиасаа өргөн дэвшүүлж.

Монгол Улсын төр засгаас их, дээд сургууль, мэргэжлийн боловсролын байгууллагуудын үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоо, инновацын менежментийг нутагшуулах, эрдэм шинжилгээ, боловсрол, сургалтын агуулга, арга зүйг олон улсын жишигт хүргэх, судалгааны болон судалгаанд суурилсан их сургууль болгон хөгжүүлэх бодлогыг баримталж байна. Энэхүү бодлого, зорилгыг хэрэгжүүлэхэд багш, эрдэмтэн судлаачид, Та бүхний гүйцэтгэх үүрэг чухал юм.

Боловсролын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд тус сургуулийн сургалтын үйл ажиллагааг явуулахад нэн шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгуулахаар ажиллаж байна.

Түүнчлэн ҮБХИС-ийн хөгжлийг дэмжих ажлын хүрээнд "Кибер аюулгүй байдлын сургалтын төв"-ийг шинээр байгуулж, Төв номын сангийн шинэ барилгыг ашиглалтад хүлээн аваад байгаа бөгөөд цаашид сургуулийн "Нэгдсэн лаборатори", "Алба хаагчдын хүүхдийн цэцэрлэг", "Оюутны дотуур байр", "Жагсаалын талбайн шинэчлэлт" зэрэг томоохон төсөл, хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Мөн боловсролын эрх зүйн орчны шинэчлэлийг хэрэгжүүлэх, их сургуулийн сургалт,



эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх, туршилт, судалгаа явуулах нөхцөлийг сайжруулах, шинэ шатанд гаргах, чанарыг ахиулах, багш, эрдэмтэн, судлаачдын нийгмийн баталгааг дээшлүүлэхэд бид анхаарал хандуулж ажиллах болно. Сая дурдсан бүтээлч ажлууд биеллээ олж олон улсын нийтлэг жишигт нийцсэн, судалгаанд суурилсан их сургууль болох цаг удахгүй ирнэ гэдэгт итгэж байгаагаа илэрхийлье" гэлээ.

"Оюутан цэрэг" хөтөлбөрийн ерөнхий зохицуулагч, Монгол Улсын Ардын багш, доктор (Sc.D), профессор Г.Мягмаржав эрдмийн хамт олноо төлөөлөн сэтгэгдлээ хуваалцсан юм.

1969 онд Ховд аймагт Багшийн сургуулийг дүүргэж улмаар Увс аймгийн Ховд суманд бага ангийн багшаар очиж ажлын гараагаа эхлүүлснээс хойш 53 жил өнгөрчээ. Энэ хугацаанд Бага ангийн багшаас Их сургуулийн доктор, профессор, МУ-ын Гавьяат багш, МУ-ын Ардын багш гэсэн эрхэм

хүндэт цол тэмдгүүдийг хүртэж 20 гаруй мянган шавийг бэлтгэхийн сацуу эрдэм шинжилгээний бүтээлүүд, багш бүрийн ширээний номыг бичиж, нийтлүүлэн МУ-ын Боловсролын салбарт өөрийн хувь нэмрээ оруулсан байна. Багш нарын баяр бол зөвхөн ёслолын шинж чанартай гэхээс илүү өнгөрсөн хугацаанд болоод ирээдүйд хийж гүйцэтгэх ажлуудаа багш бүр дүгнэдэг, төлөвлөдөг нэг ёсны ажлын шинж чанарыг агуулсан баяр байдаг. Энэ завшааныг ашиглаад намайг сурган хүмүүжүүлсэн болоод өөрийн бэлтгэсэн шавь нар, ҮБХИС-ийн эрдмийн хамт олондоо Монголын багш нарын 56 дахь баярын мэндийг өргөн дэвшүүлжээ. Эрдмийг түгээгч ариун үйлсийн эзэд минь сайхан баярлаарай" хэмээлээ.

Мөн баярын хурлын төгсгөлд Батлан хамгаалах болон боловсролын салбар, Зэвсэгт хүчинд удаан жил үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим эрдэмтэн багш, сурган хүмүүжүүлэгч нарт шагнал гардуулсан юм. **Ө.НАСАНТОГТОХ**

Редакцийн зурвас



2025 ОНД "ХОС МОРЬТОЙ" ОРОХЫН ТУЛД...

2025 он. Түүхэн он цаг ойртсоор байна. "Монгол хэлний тухай" шинэ хуульд зааснаар тухайн жилээс манай улсын төрийн алба хос бичигт шилжинэ. Өөрөөр хэлбэл, үндэсний монгол бичгээ албан ёсоор дахин сэргээж төрийн албаа хөтөлж эхлэх юм.

Монгол бичгээ төрийн бичиг болгох, хэрэглээний бодитой орчин бүрдүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг оролцоо юу юунаас чухал. "Соёмбо" сонины редакциас уншигчдадаа зориулан Монгол бичгийн хичээл цувралаар нийтлэхээр санаачилж, багшлах санал тавьсныг хүлээн авахад таатай байна.

Эрхэм хүндэт уншигч та

бүхэн "Соёмбо-Мэдээ" цахим сониноор дамжуулан ажлын өдрүүдээр миний хөтөлж зайны сургалтын хичээлийг хүлээн аваарай.

Бид монгол бичгийн хичээлийг бэлтгэхдээ бүр эхнээс нь, ямар ч ойлголгүй хүний түвшнээс хүргэж эхлэх тул уншигч танд хөнгөн хялбар, товч цомхон, цаг завьг тань үрэхээргүй байх болно.

Монгол хүн, монгол цэргийн хүн та монгол бичгээ сайн, сайхан сурч аваарай.

Хөтөч: "Хүмүүн бичиг" сонины эрхлэгч, судлаач-багш, сэтгүүлч, МУСГЗ, Б.ЭЛБЭГЗАЯА

Цаг үе, үйл явдал

ТАНД ХЭРЭГТЭЙ

1000 АГЕНТЫН ТУСГАЙ АЖИЛЛАГАА ӨДӨРЛӨГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



1000 "Агент" ийн тусгай ажиллагаа

Үндэсний батлан хамгаалах их сургууль болон Cinemanext кино театр, Fantastic Production хамтын үйл ажиллагааны хүрээнд 2022.10.05-ны өдөр зохион байгуулсан ZURA "Цурам ажиллагаа" 1000 "Агент"-ийн тусгай ажиллагаа амжилттай болж өндөрлөлөө.

Эрдэмтэн багш, офицер ахлагч, сонсогч, оюутан сурагч, хугацаат цэргийн албан хаагчдын албан үүрэг, хичээл сургалтын үйл ажиллагаанаас гадуурх тэдний нийгмийн оролцоон дахь идэвхийг хангах, мэргэжлийн онцлогт тохирсон кино контент, үзвэр үйлчилгээг үзүүлэн нэгэн өдрийг нийт их сургуулийн бүрэлдэхүүнээрээ хөгжилдөж өнгөрөөлөө.

Эх орон, тусгаар тогтнолын үнэ цэнийг мэдрүүлэх, тангараг өргөсөн төрийн хүн гэдэг ямар өндөр хариуцлагатай байх ёстой гэсэн мессежийг ирээдүйд эх орноо батлан хамгаалахад суралцаж буй суралцагчид маань энэхүү киногоор ойлгосон гэдэгт итгэж байна.

ҮБХИС-ийн нийт 870 гаруй бие бүрэлдэхүүн (Багш, албан хаагч, оюутан, сонсогч, хугацаат цэргийн албан хаагч) оролцож нэгэн өдрийг дурсамж дүүрэн хайртай жүжигчидтэйгээ ярилцлага хийн зураг даруулж чадварлаг жүжигчид хамт олонтой "Цурам ажиллагаа" киногоо шимтэн шимтэн үзлээ.



1000 "Агент" ийн тусгай ажиллагаа

“ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН ЛАВЛАХ” АППЛИКЕЙШНД “МОНГОЛ УЛСЫН ЦЭРГИЙН НИЙТЛЭГ ДҮРМҮҮД” ОРЛОО



“Цэргийн алба хаагчийн эрх зүйн лавлах” аппликейшнд шинэчлэл хийгдэж МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 180 дугаар ЗАРЛИГААР батлагдсан “МОНГОЛ УЛСЫН ЦЭРГИЙН НИЙТЛЭГ ДҮРМҮҮД” орлоо.

Тухайн аппликейшнийг Төрийн нууцын зэрэглэлд хамаарахаас бусад төрийн албаны хууль, дүрэм журам болон батлан хамгаалах салбарын хэмжээнд дагаж мөрддөг цэргийн албаны холбогдолтой хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг цахим хэлбэрээр нэгтгэх, батлан хамгаалах салбарын бие бүрэлдэхүүний цэргийн алба, сахилга зохион байгуулалт, төрийн албан хаагчийн болон офицер, ахлагчийн ёс зүйг дээшлүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор


боловсруулсан юм.

Одоогоор тус аппликейшнд Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Батлан хамгаалах багц хууль, Монгол улсын цэргийн нийтлэг дүрмүүд-2022, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн ёс зүйн дүрэм, Цэргийн албан хаагчийн хувцас өмсөх дүрэм, Цол олгох журам, Энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах журам зэрэг эрх зүйн баримтуудыг оруулаад байна. Гар утасныхаа App store, Google Play Store програмуудын хайх хэсэгт “ЦАХ-ийн эрх зүй” гэж бичихэд ЗХЖШ-ын лого бүхий “ЦАХ-ийн эрх зүй” аппликейшн гарч ирнэ. Мөн дараах QR кодыг гар утсаараа уншуулан татаж авна уу.

ЕСӨН АЙМАГТ “ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ТӨВ”- ИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛЖЭЭ

Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын газартай хамтран иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, үзлэг оношилгоо, шинжилгээ, тусламж үйлчилгээ үзүүлэх асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэхээр Өвөрхангай, Увс, Завхан, Дундговь, Говьсүмбэр, Булган, Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар гэсэн аймгуудад “Эрүүл мэндийг дэмжих төв” байгуулжээ.

2022 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Зэвсэгт хүчний салбарт 12, Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 30, өөрийн хөрөнгө оруулалтаар 1, гадаадын зээл тусламжаар 1, нийт 44 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаагаас 25 нь бүрэн ашиглалтад шилжээд байгаа аж.



Үлдсэн 19 бүтээн байгуулалтын ажлын явцыг улсын комисс цаг тухай бүрд нь захиалагчийн техник, хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж ашиглалтад оруулна гэж холбогдох албаны хүмүүс хэллээ.

Фото агшин

ЗАРЛАЛ

Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны чадавх, оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “НҮБ-ын штабын ажилтны дамжаа”-г 2022 оны 10 дугаар сарын 17-ноос 11 дүгээр сарын 04-ний өдрүүдэд Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвд зохион байгуулна.

Дамжаанд суралцах хүсэлтэй цэргийн алба хаагчид ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст доорх материалыг бүрдүүлэн 2022 оны 10 дугаар сарын

11-ний өдрийн дотор ирүүлнэ.

- Үүнд:
1. Харьяа анги, байгууллага, төрлийн цэргийн командлал болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;
 2. Жолооны үнэмлэхийн хуулбар;
 3. Товч судалгаа /Анги, албан тушаал, цол, овог нэр, нас, боловсрол, цэргийн мэргэжил, дамжаа, Анги байгууллагад ажилласан байдал, ЭДА-нд үүрэг гүйцэтгэсэн байдал/

Анги	Албан тушаал	Цол	Овог, нэр	Нас	Боловсрол, цэргийн мэргэжил, дамжаа	Анги байгууллагад ажилласан байдал	Одоогийн албан тушаалд томилогдсон огноо	ЭДА-нд үүрэг гүйцэтгэсэн байдал

Жич: Шаардлагатай нэмэлт мэдээллийг АУГ-ын ЭДАХ-ийн psod@mil.gov.mn цахим шуудангаар болон /3203, 88136757, 99732447/ дугаарын утсанд холбогдож тодруулна уу.

ЗХЖШ-ЫН АУГ-ЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС



ОХУ-ын Цэргийн академи, Их, Дээд сургуульд суралцах бүрэлдэхүүнийг үдэх ёслолын ажиллагааны үеэр